


Г.Ловор

Аж төрөх
ухаан

НОГООН ГЭРЭЛ



II
ангийнханд
зориулав

Г.Ловор
Ногоон гэрэл

Бага сургуулийн 2-р ангийн сурагчдад зориулав.

Зураач	Л.Зулбадрах Д.Сугархүү
Хянан тохиолдуулагч	О.Мөнхтуяа
Хянагч	Ж.Гэрэлмаа
Хэвлэлийн эх бэлтгэсэн	Н.Хөдөлмөр Д.Хишигдэлгэр




Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он

Ногоон гэрэл

Өөдөөс асах гэрлийн
Өнгийг тогтоож ав!
Замын уулзвараар гарахдаа
Заавал түүнээ сана.



Улаан гэрэл асвал
Урдаас нь алхаж болохгүй!
Давхиж ирэх машинд
Дайруулж мэдэх аюултай!

Шар гэрэл асвал
Шамдаж гүйх хэрэггүй ээ!
Удаа нь асах гэрэл
Удаан хүлээлгэх ёсгүй ээ!




Ногоон гэрэл асахад
Номхон команд авах шиг
Давхиж явсан машинууд
Дараа дараалан зогсоно.

Ярайтал эгнэн жагсаж
Явган зорчигчдыг хүлээнэ.
Яг л энэ мөчид
Явж өнгөрөхийг хүснэ.



Армийн дайчдыг жагсааж
Рапорт авдаг генерал шиг
Явган зорчигчид хүндтэй
Явж өнгөрөх эрхтэй.

Явган ч гэсэн мөргөлдөх
Яаж сайн байхав.
Баруун талаа дагадаг
Бас нэг дүрэмтэй.



Ногоон гэрлээр гарч
Номоороо явааг чинь хараад
Замын цагдаа хүндэтгэж
Заагуураа буулгаж ёсолно доо.

Бага сургуулийн 2-р ангийнханд зориулав.




Монголчуудын хот хүрээ гэдэг ойлголт юунаас үүссэн бэ?



Хот сууринд суугчдын өдөр тутмын мөрдөх нэг чухал хууль бол замын хөдөлгөөний дүрэм.



Малчдын ажиллах, амьдрах нөхцөлөөс ургаж гарсан таатай сууц.



Монголчуудын амьдралын гол хэрэглээ идээ шүүс, хоол ундаа цаг хугацаа, ёс горимтой зооглодог тухай.



Хүн төрөлхтөн өдөр тутмын мэдээлэл сонирхон олж авдгийн ачаар амьдрал ахуйгаа хөгжүүлэн зохицуулж, ирээдүйгээ төсөөлдөг.



Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлж буй "Хөдөөгийн боловсролыг дэмжих (READ) төсөл"-ийн хүрээнд хэвлэв. Худалдахыг хориглоно.